



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/241

Улаанбаатар хот

### Хяналтын хуудас батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.3.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, Гал түймрийн улсын хяналтын дүрмийн 1.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Худалдаа, олон нийтийн барилга байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ыг нэгдүгээр, “Автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/-ын барилга байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ыг хоёрдугаар, “Шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн техник ашигладаг барилга байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ыг гуравдугаар, “Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ыг дөрөвдүгээр, “Шатахуун түгээх станцын барилга байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гал түймрийн улсын хяналтын байцаагчид төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг явуулахдаа батлагдсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилласугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2021 оны 22 дугаар сарын 18-ны өдрийн  
А/241 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХУДАЛДАА, ОЛОН НИЙТИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хяналтын байгууллага:

Шалгуулагч байгууллагын нэр:

Объектын нэр:

Байгууллагын регистрийн дугаар:

Захирлын нэр, утасны дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:

Шалгалтад хамрагдсан барилга байгууламжийн зэрэглэл

Гал түймрийн онц аюултай

Гал түймрийн аюултай 1 дүгээр зэрэглэл

Гал түймрийн аюултай 2 дугаар  
зэрэглэл

Гал түймрийн аюултай 3 дугаар зэрэглэл

ШАЛГАХ ЧИГЛЭЛ

№	Хууль, норм, дүрмийн заалт	Шалгалтын асуулт	Шаардлага хангасан эсэх		Тайлбар
			Тийм	Үгүй	
<b>Хууль эрх зүй</b>					
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах.			
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.			
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис,			

		материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангах			
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.9	гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу хийлгэх			
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах.			
6	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралт <b>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм</b>	Барилга байгууламжид улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан, актаар баталгаажсан эсэх			
<b>Стандарт, норм норматив, дүрэм, журам, зааварын хэрэгжилт</b>					
1		Нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц;			
2		Гал унтраах автомашин явах зам, гарцыг түр хугацаагаар хаах шийдвэр гаргасан албан тушаалтан энэ талаар тухайн төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагад мэдэгдэж, зам, гарцыг хаасан хугацаанд тойрч гарах замын чиглэлийг зааж, саадыг даван гарах боломжоор хангаж, усны эх үүсвэрт хүрэх гарцыг гаргасан байна.			
3	МУ-ын Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоол "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.2.1, 2.14, 2.17, 2.19, 2.26, 2.27, 2.35.4, 2.35.9.	Барилга байгууламжийг түрээслэх гэрээнд тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах шаардлага, хариуцлагын талаар заавал тусгана.			
4		Барилга байгууламжийн аврах зам, гарцыг тухайн барилгад байрлах хүний тоог харгалзан төлөвлөж, аврах зам, гарцын өргөний хэмжээг аврах ажиллагаа явуулах хугацааны шаардлагыг хангахуйц байдлаар тогтооно.			
5		Түлшээр цэнэглэх халаагч, гэрэлтүүлэгч хэрэгслийг өөр төрлийн шатах шингэнээр (бензин, спирт г.м) цэнэглэхийг хориглоно.			
6		Тос, шатах шингэн болсон ажлын хувцсыг тусгайлсан газарт байрлуулсан металл шүүгээнд өлгөж хадгална.			

7		Зоорийн болон хагас зоорийн давхарт дүрмээр зөвшөөрөгдснөөс бусад шатамхай болон хялбар авалцан асах шингэн, дарь, тэсэрч дэлбэрэх бодис, материал, хийн баллон зэрэг галын аюултай бодис, материалыг хадгалах, хэрэглэх			
8		Барилгын дотор зохион байгуулалт, өрөө тасалгаа, байр байршлын өөрчлөлт хийснээр хүмүүсийг аврах үйл ажиллагаа удаашрах, гал түймэр унтраах байгаж хэрэгсэл, усан хангамжид хүрэх бололцоо хумигдах, гал унтраах автомат төхөөрөмжийн унтраах талбай байгасах тохиолдолд барилгын дотоод засвар, өөрчлөлт хийх			
9		Зоорь ба хагас зоорийн давхарт тусгайлан авч үзсэнээс бусад нөхцөлд шатамхай хий ба шингэн мөн хялбар авалцан асах материал агуулдаг буюу хэрэглэдэг өрөө тасалгаа байрлуулахыг зөвшөөрөхгүй			
10	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02-ийн , 6.9 дэх заалт 7.7 дахь заалт	Авран хамгаалах ба аврах гарцын байдал холбогдох шаардлага хангасан эсэх Гарцыг дараах нөхцөлд аврах зориулалттай гэж тооцно. а\Нэгдүгээр давхрын өрөөнөөс гадагш гарах: -шууд гарах -коридор дамжиж гарах -гонх \хөлийн өрөө\ өөр дамжиж гарах -шатны хонгилоор дамжиж гарах -коридор ба шатны хонгилоор дамжиж гарах б\Нэгдүгээр давхраас бусад аль ч давхрын өрөөнөөс: -шатны хонгилд буюу 3-р төрлийн шатанд шууд гарах			
11	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	Тухайн барилга байгууламжид гал унтраах автомат тоног төхөөрөмж төлөвлөгдсөн эсэх,	- усны насос, усан сангийн байнгын ажиллагаа хэвийн эсэх -Удирдлагын зангилааны ажиллагаа хэвийн эсэх		
12	Гал унтраах автомат тоног	Галын дохиоллын	-Утаа мэдрэгч		

	төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	хэрэгсэл төлөвлөгдсөн эсэх мэдрэгч	-Дулааны -Удирдлагын самбар -гар мэдээлэгч			
13	Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-02-16/	Гал түймэр унтраах галын дотор болон гадна усан хангамж	-Гал унтраах хушуу -Галын хоолой -Холбох тотго -Барилгын гадна гидрант төлөвлөгдсөн эсэх			
14	Агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-02/-ийн 7 дугаар зүйл	Агаарын хаялт ба утаа зайлуулах системийн хэвийн ажиллагааг хангасан эсэх				
15	Гал түймрээс. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS5566:2020 стандарт	Барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл стандартын дагуу байгаа эсэх.				
16	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143 : 2013	Энэхүү стандартын холбогдох заалтуудыг хангаж байгаа эсэх				
17		Барилга байгууламжийн цахилгаан шугам сүлжээний угсралт, цахилгаан тоног төхөөрөмжийн төлөвлөлт нь галын аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх,				
18	Цахилгаан байгууламжийн дүрэм /БД 43-101-03/-ийн 2.1.8, 2.1.9 дэхь заалт	Цахилгаан утас ба кабелийн салбарлага, холболтыг шахуурга, гагнуур, гагнаас, гагнаас буюу боолтон хавчаар зэргийг ашиглан мөрдөж байгаа "Цахилгаан техникийн ажил БНБД 3 05.06.90-ийн дагуу гүйцэтгэнэ. Дамжуулах утас ба кабелийн салбарлага, холболтыг хийдээ залгалтын судлыг дахин хийж болзошгүй байдлыг тооцож, нөөцтэй тайрахаас гадна үзлэг, засвар хийх боломжтой байвал зохино.				

19	Олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03*/11 (Нэмэлт) Худалдааны павильон, түргэн үйлчилгээний цэгт тавигдах шаардлага	Олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03*/11 (Нэмэлт)-ийн Заавал мөрдөх 10 дугаар хавсралт Автомат гал унтраагч төлөвлөхөд тавигдах шаардлага			
		Зөвлөмжийн 11 дүгээр хавсралт Олон нийт, сургалт хүмүүжлийн байгууллагын барилгын хоршсон цогцолборын ойролцоо бүрэлдэхүүн			

БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналт шалгалт хийсэн газар, хэлтэс, албан тушаал	Хяналт шалгалт зохион байгуулсан албан тушаалтан / овог, нэр/	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан / овог, нэр/
	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/